



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Төрийн өмчид барилга үе шаттай
шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь заалт, Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны Е/05 дугаар албан бичгээр өгөгдсөн чиглэл, Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” хот байгуулалтын баримт бичиг, Засгийн газрын 2021 оны 282 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй “Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор” барилгын хөрөнгийн зарим хэсэг /22 тэрбум төгрөг/ эх үүсвэр батлагдаж, ашиглалтад орох болсонтой холбогдуулан батлагдсан улсын төсвийн хүрээнд Нийслэлийн Засаг захиргааны “Хангарди” ордны барилгыг төрийн өмчид үе шаттай шилжүүлсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100480